

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дөргөн сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/153/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Цахим актив аудит ХХК -ын Аудитор: Д.Балжинням Утас:70432545 Цахим хаяг: Damiranbaljinnyam573@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
3.1. Төлбөрийн акт	13
3.2 Албан шаардлага.....	13
3.3 Зөвлөмж.....	14
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	15
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл	18

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2024.02.27 № 207
танай _____-ны № _____-т

166
ДӨРГӨН СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ ЭМЧ
Б.ТӨГСБИЛЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.1, 16.5.2 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтууд, Монгол улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтад заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаартай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Байгууллагын барилга байгууламж дансанд бүртгэлтэй 10.0 сая төгрөгийн өртөгтэй Эмийн сангийн байрыг бусдад ашиглуулсан, төсвийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт ашиглалтад хяналт хэрэгжүүлээгүй,
- Зардлын эдийн засгийн ангилал зерчин гүйлгэн зарцуулалт хийсэн 4.2 сая төгрөг
- Жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодолгүйгээр шатахуун зарцуулсан, шатахууны зарцуулалтын тайлан байхгүй 28.6 сая төгрөг
- Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй 7.6 сая төгрөг

8426050520

- Бараа материалын тайлан байхгүй, эм боох материалын тооцоо бодоогүй, эмийн зарлагыг тухай бүр гаргаагүй, жилийн эцэст бөөн дүнгээр зарлагадсан, жилийн эцсийн тооллогын үлдэгдэл тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй 21.9 сая төгрөг
- Тайлант онд зарцуулсан эмийг анхан шатны баримттай тулган түүвэрлэн шалгахад 5 нэр төрлийн 1468 ширхэг 1.7 сая төгрөгийн цагийн тариаг илүү зарлагадсан

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 5353 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний 1.7 сая төгрөгийн санхүүжилтийн авлага бүртгэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд урсгал зардлаас 10.2 сая төгрөгийн, харьяа дээд шатны байгууллагын хөрөнгө оруулалт болон хандив тусламжаар 10.3 сая төгрөг, нийт 20.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 177.9 сая төгрөгийн тусгай зориулалттай материал, эм боох материал, бичиг хэрэг, аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, түлш шатах тослох материал, хүнсний материал төсвийн хөрөнгөөр авч данс бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 5 зорилго 10 хөтөлбөр, 30 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлээр 95 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд сумын Засаг даргаас 75.6 хувиар дүгнэж, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээг аймгийн Эрүүл мэндийн даатгалын газраас 79.5 хувиар тус тус дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	(Төгрөгөөр)
			Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>248,535,821.98</u>	<u>105,747,325.08</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	444,000.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	444,000.00	-
3121	Төгрөг	444,000.00	-
31211	Төрийн сангийн харилцах	444,000.00	-
33	АВЛАГА	126,975,601.53	2,740,750.08
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	295,933.42	369,992.88
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	126,052,786.18	1,743,875.27
335	Бусад авлага	626,881.93	626,881.93
3351	Байгууллагаас авах авлага	626,881.93	626,881.93
34	УРЬДЧИЛГАА	-	24,033,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	24,033,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	121,116,220.45	78,973,575.00
351	Түүхий эд материал	34,427,303.05	38,632,056.77
35110	Тусгай зориулалттай материал	2,064,062.70	5,572,429.60
35130	Эм боох материал	32,363,240.35	33,059,627.17
354	Хангамжийн материал	86,688,917.40	40,341,518.23
35420	Аж ахуйн материал	59,303,317.40	37,089,518.23
35440	Түлш, шатах тослох материал	-	2,080,000.00
35460	Хүнсний материал	2,515,600.00	1,172,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,003,418,275.90</u>	<u>1,867,623,092.02</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,003,418,275.90	1,867,623,092.02
392	Биет хөрөнгө	1,987,561,376.05	1,851,766,192.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,853,902,337.61	1,853,902,337.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	(183,087,486.81)	(273,848,809.05)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	60,377,554.00	60,377,554.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(27,845,925.51)	(36,333,147.39)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	279,617,418.94	297,101,518.94
39206	Хуримтлагдсан элэгдэл	(75,043,115.83)	(122,271,757.98)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,368,725.40	89,378,725.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,977,631.75)	(16,789,729.36)
39217	Ном	249,500.00	249,500.00
393	Биет бус хөрөнгө	15,856,899.85	15,856,899.85
39301	Програм хангамж	732,000.00	732,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(709,150.15)	(709,150.15)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,834,050.00	15,834,050.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,251,954,097.88</u>	<u>1,973,370,417.10</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>6,166,510.56</u>	<u>14,453,455.23</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,166,510.56	14,453,455.23
413	Өглөг	6,166,510.56	14,453,455.23
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,425,028.87	8,093,435.04
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,741,481.69	6,360,020.19
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,245,787,587.32</u>	<u>1,958,916,961.87</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,245,787,587.32	1,958,916,961.87

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	191,439,640.00	191,439,640.00
51101	Өмч: - төрийн	191,439,640.00	191,439,640.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,776,279,245.26	1,489,408,619.81
51210	Өмнөх үеийн үр дүн	1,776,279,245.26	1,800,312,245.26
51220	Тайлант үеийн үр дүн	-	(310,903,625.45)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	278,068,702.06	278,068,702.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,251,954,097.88</u>	<u>1,973,370,417.10</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,364,060,423.07	1,155,921,546.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	283,461,185.45	57,055,864.03
120	Нийтлэг татварын бус орлого	283,461,185.45	57,055,864.03
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	283,461,185.45	57,043,184.03
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	42,785,969.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	283,461,185.45	14,257,215.03
120009	Бусад орлого	-	12,680.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,080,599,237.62	1,098,865,682.30
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	130,338,500.00	128,017,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	130,338,500.00	128,017,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	950,260,737.62	970,848,282.30
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	950,260,737.62	970,848,282.30
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,183,886,161.91	1,466,825,171.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,183,886,161.91	1,466,825,171.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,177,823,980.47	1,423,016,981.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	555,882,341.22	736,508,967.45
210101	Үндсэн цалин	309,941,871.19	390,802,976.34
210102	Нэмэгдэл	178,897,420.88	263,326,060.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,104,249.15	63,283,285.33
210104	Урамшуулал	32,938,800.00	19,096,645.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,051,413.33	164,349,296.57
210201	Тэтгэврийн даатгал	52,180,699.99	92,033,338.91
210202	Тэтгэмжийн даатгал	5,657,810.16	41,471,715.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,233,421.83	5,178,152.52
210204	Ажилгүйдлийн даатгал	69,232,953.38	4,420,903.43
210205	Эрүүл мэндийн даатгал	10,746,527.97	21,245,186.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,793,718.56	124,407,209.98
210301	Гэрэл, цахилгаан	2,537,818.56	3,387,609.98
210302	Түлш, халаалт	119,000,000.00	119,009,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,255,900.00	2,010,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,737,308.00	36,639,840.00
210401	Бичиг хэрэг	2,062,495.00	3,716,050.00
210402	Тээвэр, шатахуун	34,184,050.00	28,609,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,793,418.00	3,192,600.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	697,345.00	1,011,340.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	110,000.00
2105	Нормативт зардал	189,654,558.50	121,697,992.95
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	167,430,118.50	105,472,892.95
210502	Хоол, хүнс	17,253,440.00	16,225,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,780,600.00	25,769,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	320,000.00
210604	Урсгал засвар	2,780,600.00	25,449,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,492,000.00	4,472,000.00
210702	Дотоод албан томилолт	1,492,000.00	4,472,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,831,300.00	8,573,239.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,001,800.00	7,709,239.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	414,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	119,600,740.86	200,599,435.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,047,962.60	44,310,151.73
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	86,552,778.26	156,289,283.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,062,181.44	43,808,190.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	41,634,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	41,634,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,174,190.02
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,174,190.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>180,174,261.16</u>	<u>(310,903,625.45)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>180,174,261.16</u>	<u>(310,903,625.45)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>954,546,451.44</u>	<u>1,265,973,242.21</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	42,798,649.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	42,798,649.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	42,785,969.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	42,785,969.00
120009	Бусад орлого	-	12,680.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	954,546,451.44	1,223,174,593.21
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	130,338,500.00	128,017,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	130,338,500.00	128,017,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	824,207,951.44	1,095,157,193.21
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	824,207,951.44	1,095,157,193.21

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,090,947,347.03</u>	<u>1,256,262,242.21</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,090,947,347.03	1,256,262,242.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,084,885,165.59	1,212,454,052.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	595,490,650.68	796,534,412.41
210101	Үндсэн цалин	274,369,631.44	405,906,131.20
210102	Нэмэгдэл	248,124,716.04	275,748,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,374,000.00	57,341,712.41
210104	Урамшуулал	41,347,708.65	57,537,968.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,230,100.00	100,729,504.90
210201	Тэтгэврийн даатгал	66,116,200.00	67,508,504.90
210202	Тэтгэмжийн даатгал	7,778,400.00	8,324,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,889,400.00	4,162,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,889,400.00	4,162,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,556,700.00	16,573,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	128,855,900.00	124,407,209.98
210301	Гэрэл, цахилгаан	2,537,818.56	3,387,609.98
210302	Түлш, халаалт	125,062,181.44	119,009,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,255,900.00	2,010,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,932,813.00	42,860,740.00
210401	Бичиг хэрэг	5,969,000.00	4,521,950.00
210402	Тээвэр, шатахуун	34,184,050.00	30,689,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,793,418.00	3,137,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,486,345.00	1,011,340.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,500,000.00	3,500,000.00
2105	Нормативт зардал	180,078,178.91	117,381,719.27
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	154,821,838.91	100,298,219.27
210502	Хоол, хүнс	17,331,340.00	14,881,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,925,000.00	2,202,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,407,600.00	4,545,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,493,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,566,000.00	1,443,000.00
210604	Урсгал засвар	11,348,600.00	3,102,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,492,000.00	4,472,000.00
210702	Дотоод албан томилолт	1,492,000.00	4,472,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,856,800.00	9,570,939.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,001,800.00	8,706,939.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	414,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,541,123.00	11,952,526.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,541,123.00	11,952,526.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,062,181.44	43,808,190.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	41,634,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	41,634,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,062,181.44	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,062,181.44	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,174,190.02
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,174,190.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(136,400,895.59)</u>	<u>9,711,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	33,213,000.00	10,155,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,213,000.00	10,155,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	33,213,000.00	10,155,000.00
222001	Тоног төхөөрөмж	33,213,000.00	10,155,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(33,213,000.00)</u>	<u>(10,155,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(169,613,895.59)	(444,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		444,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,439,640.00	278,068,702.06	1,597,259,984.10	2,066,768,326.16
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191,439,640.00	278,068,702.06	1,597,259,984.10	2,066,768,326.16
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,439,640.00	278,068,702.06	1,597,259,984.10	2,066,768,326.16
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	191,439,640.00	278,068,702.06	1,597,259,984.10	2,066,768,326.16
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	24,033,000.00	24,033,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191,439,640.00	278,068,702.06	1,621,292,984.10	2,090,801,326.16
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(310,903,625.45)	(310,903,625.45)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,439,640.00	278,068,702.06	1,310,389,358.65	1,779,897,700.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)		
	Үзүүлэлт	Тайлант оны

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,343,346,400.00	1,264,243,052.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,343,346,400.00	1,264,243,052.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,292,808,400.00	1,222,609,052.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	814,529,800.00	796,534,412.41
210101	Үндсэн цалин	402,194,100.00	405,906,131.20
210102	Нэмэгдэл	276,288,500.00	275,748,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,047,200.00	57,341,712.41
210104	Урамшуулал	78,000,000.00	57,537,968.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,497,100.00	100,729,504.90
210201	Тэтгэврийн даатгал	68,201,100.00	67,508,504.90
210202	Тэтгэмжийн даатгал	8,324,000.00	8,324,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,162,000.00	4,162,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,162,000.00	4,162,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,648,000.00	16,573,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,569,600.00	124,407,209.98
210301	Гэрэл, цахилгаан	4,550,000.00	3,387,609.98
210302	Түлш, халаалт	119,009,600.00	119,009,600.00
210303	Цэвэр, бохир ус	2,010,000.00	2,010,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,243,800.00	42,860,740.00
210401	Бичиг хэрэг	5,431,400.00	4,521,950.00
210402	Тээвэр, шатахуун	34,072,800.00	30,689,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,137,600.00	3,137,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,102,000.00	1,011,340.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,500,000.00	3,500,000.00
2105	Нормативт зардал	129,888,100.00	117,381,719.27
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	104,673,100.00	100,298,219.27
210502	Хоол, хүнс	17,340,000.00	14,881,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,875,000.00	2,202,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,192,000.00	14,700,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,744,200.00	10,155,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	1,443,000.00
210604	Урсгал засвар	12,447,800.00	3,102,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,300,000.00	4,472,000.00
210702	Дотоод албан томилолт	5,300,000.00	4,472,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,461,300.00	9,570,939.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,385,200.00	8,706,939.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	-

210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	258,600.00	-
210807	Газрын төлбөр		
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	414,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,462,500.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,126,700.00	11,952,526.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,126,700.00	11,952,526.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,538,000.00	41,634,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,538,000.00	41,634,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,538,000.00	41,634,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,343,346,400.00	1,263,799,052.19
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	128,017,400.00	125,843,209.98
132001	Орон нутгийн төсвөөс	128,017,400.00	125,843,209.98
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,163,619,600.00	1,095,157,193.21
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,163,619,600.00	1,095,157,193.21
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	51,709,400.00	42,798,649.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,265,400.00	42,798,649.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	444,000.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		444,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 126,798.5 мянган төгрөгийн алдаа¹ зөрчил илэрч, санхүүгийн тайланд 52,783.1 мянган төгрөгийн алдааг залруулга хийлгэлээ. Үүнд:

- Өмнөх онд засварын зардлыг урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй, засварын материал бүртгэж он дамжсан үлдэгдэл гаргасныг буцаан зарлагадаж урьдчилж гарсан зардлаар бүртгэх 24,000.0 мянган төгрөг
- Тайлант оны ХХОАТ-ын ногдуулалтыг санхүүгийн тайланд дутуу тусгаж өглөг бууруулсан 586.9 мянган төгрөг
- Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа оруулаагүйгээс 25 нэр төрлийн хөрөнгөнд элэгдэл тооцоогүй 28,122.2 мянган төгрөг
- Тайлант оны НДШ-ийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй 74.0 мянган төгрөг

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй 74,015.4 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил² илэрсэнд 1,749.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 29,439.9 мянган төгрөгийн 2 зөрчлийг таслан зогсоох албан шаардлага, 42,826.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 13,672.4 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

3.1. Төлбөрийн акт

3.1.1 Тайлант онд зарцуулсан эмийг түүвэрлэн анхан шатны баримттай тулган шалгахад 5 нэр төрлийн 1468 ширхэг 1,749.0 мянган төгрөгийн цагийн тариаг илүү зарлагадсан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

3.2 Албан шаардлага

3.2.1 Тайлант онд Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүйтэй холбоотой 7,569.2 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.2-т "Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" , Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны 01/103 албан тоотын заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

3.2.2 Санхүүгийн тайланг хянахад бараа материалын тайлан байхгүй, эм боох материалын тооцоо бодоогүй, эмийн зарлагыг тухай бүр гаргаагүй жилийн эцэст бөөн дүнгээр зарлагадсан, жилийн эцсийн тооллогын үлдэгдэл тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй холбоотой 21,870.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь хариуцсан албан тушаалтнууд албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй, өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;, 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй ...", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Сангийн сайдын 2025 А/03 тушаал Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн журмын хавсралтын 8 зүйлийн 8.2.-д "Бараа материал нь түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, хангамжийн материал, нөөцийн бараа, бусад бараа материал бүрдэнэ.", 8.3.-д Бараа материалыг УСНББОУС 12 "Бараа материал"-ын дагуу бүртгэнэ." гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах шаардлага хүргүүлээ.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.3.1. Эдийн засгийн ангилалт, төсвийн төлөвлөлттэй холбоотой

Илрүүлэлт: Тайлант онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд батлагдсан 1,436.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр зардалд батлагдсан 2,761.0 мянган төгрөг нийт 4,197.2 мянган төгрөгийг гүйцэтгэлээр хоол хүнс, БҮТЭАЗ-н эд зүйлсийн зардалд зарцуулж, эдийн засгийн ангилал зөрчин гүйлгэн зарцуулалт хийсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", хоёрдугаар хавсралт "Зардлын эдийн засгийн ангиллын тайлбар"-т Хэрэглүүрийн гуравт " Төсөв боловсруулж батлуулах, гүйцэтгэлийн тайлан гаргах, зардлын хяналт, аудит хийхэд ашиглана", Төсвийн захирагчийн үүрэгт " Зардлын ангиллын тодорхойлолтод заасны дагуу нийцүүлж зөв бүртгэх, мэдээлэх, тайлагнах үүргийг төсвийн бүх шатны захирагчид хүлээнэ", 2103 -д" байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын тодорхойлолт", гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлын зүйл ангийг эдийн засгийн ангиллын дагуу зөв бүртгэж, зарцуулалтыг үнэн зөв гаргах,

3.3.2 Бараа материалын эм, эмнэлгийн хэрэгслийн данстай холбоотой

Илрүүлэлт: Жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодолгүйгээр шатахуун зарцуулсан, шатахууны зарцуулалтын тайлан байхгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахууны тооцоог сар бүр анхан шатны баримт үндэслэн бодож, улирал бүр дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллах

3.3.3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудлаар

Илрүүлэлт: Байгууллагын барилга байгууламж дансанд бүртгэлтэй 10.0 сая төгрөгийн өртөгтэй Эмийн сангийн байрыг бусдад ашиглуулсан, төсвийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт ашиглалт байхгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эмийн сангийн байрыг буцаан авч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавин ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
							Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Өмнөх онд засварын зардлыг урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй, засварын материал бүртгэж он дамжсан үлдэгдэл гаргасныг буцаан зарлагдаж урьдчилж гарсан зардлаар бүртгэх	1	24,000.0			1	24,000.0	1	24,000.0
Тайлант оны ХХОАТ-ын ногдуулалтыг санхүүгийн тайланд дутуу тусгаж өглөг бууруулсан	1	586.9			1	586.9	1	586.9
Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа оруулаагүйгээс 25 нэр төрлийн хөрөнгөнд элэгдэл тооцоогүй	1	28,122.2	1	28,122.2			1	28,122.2
Тайлант оны НДШ-ийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй	1	74.0	1	74.0			1	74.0
Дүн	4	52,783.1	2	28,196.2	2	24,586.9	4	52,783.1

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Байгууллагын барилга байгууламж дансанд бүртгэлтэй эмийн сангийн байрыг бусдад ашиглуулсан, төсвийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт ашиглалт байхгүй байна.	1	10,019.5					1	10,019.5		
Тайлант онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал зөрчин гүйлгэн зарцуулалт хийсэн	1	4,197.2					1	4,197.2		
Жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодолгүйгээр шатахуун зарцуулсан, шатахууны зарцуулалтын тайлан байхгүй	1	28,609.8					1	28,609.8		
Тайлант онд Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй	1	7,569.2			1	7,569.2				
Бараа материалын тайлан байхгүй, эм боох материалын тооцоо бодоогүй, эмийн зарлагыг тухай бүр гаргаагүй, жилийн эцэсд бөөн дүнгээр зарлагдсан, жилийн эцсийн тооллогын үлдэгдэл	1	21,870.7							1	21,870.7

тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй										
Тайлант онд зарцуулсан эмийг анхан шатны баримттай тулган түүвэрлэн шалгахад 5 нэр төрлийн 1468 ширхэг цагийн тариаг илүү зарлагдсан	1	1,749.0	1	1,749.0						
Дүн	6	74,015.4	1	1,749.0	1	7,569.2	3	42,826.5	1	21,870.7

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		